



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/568

Эрдэнэт


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2, Ахмад настны тухай хуулийн 13.4 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 09 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ач санах" дэд хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчлөл бууруулах зорилгоор Буурлын чагнуур ТББ-тай хамтран зохион байгуулах сургалтын зардалд 1000000 төгрөгийн, Технологийн сургуулийн ахмадын зөвлөлөөс санаачлан зохион байгуулж буй сургууль сурталчилах үйл ажиллагаанд 1500000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг "Ач санах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ